Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй /үр нөлөөгүй* байна.

Дотоод хяналттай холбоотойгоор төсвийг дутуу төлөвлөж өглөг, авлага нэмэгдүүлсэн эсэхийг шалгахар горим хэрэгжүүлсэн.

Горим сорилоор өмнөх оны 1.7 сая төгрөгийн өглөгийг, 121.7 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж, тайлант хугацаанд 1.3 сая төгрөгийн авлага нэмэгдэж үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

Дотоод аудит /аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах/ дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ сумын ЭМТ нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг шинэчлэн батлаагүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46.1 сая төгрөгөөр буюу 6.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| | /мянган төгрөгөөр/ | | |
|--|--------------------|-----------------|-----------------|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 7997.9 | 25171.9 | 17174.0 |
| Авлага | 121670.4 | 1292.9 | -120377.5 |
| Бараа материал | 134403.1 | 192873.6 | 58470.5 |
| Үндсэн хөрөнгө | 458381.2 | 456994.5 | -1386.7 |
| Нийт хөрөнгө | 722452.6 | 676332.9 | -46119.7 |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 279647.3 | 279647.3 | 0 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 722452.6 | 676332.9 | -46119.7 |

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 58470.5 мянган төгрөгөөр өсөж, үндсэн хөрөнгө 1386.7 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 447.0, орон нутгийн төсвөөс 55.0, улс төсвөөс 258.8 сая төгрөгөөр нийт зарлагыг 760.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас 1.9 сая төгрөгөөр санхүүжилтийг тодотголоор нэмж баталсан.

Энэ нь гэрэл цахилгааны үнэ нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 539.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 53.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1.3 сая төгрөгийг ЭМГ-аас, 120.4 сая төгрөгийг өмнөх оны даатгалын авлага, 65.7 сая төгрөгийг ЭМД-аас тус тус санхүүжилт авч орлогоо бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр нийт 779.9 сая төгрөгийн санхүүжилт авч 762.7 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 17.2 сая төгрөг нь үйл ажиллагааны зардлаас хэмнэгдэж дансандаа үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 762.7 сая төгрөг буюу 97.7 хувьтай байгаа цалингийн зардлыг 4.5, НДШ-ийн зардлыг 14.2 сая төгрөг тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--------------------|---------------------------------------|------------|-----------|---------|---------|
| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
| 1 | 1 иргэнд ногдох нормативаар | 332035.4 | 318275.0 | 13760.4 | 95.8 |
| 2 | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 212830.5 | 221886.2 | -9055.7 | 104 |
| 3 | Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан | 181899.2 | 169403.9 | 12495.3 | 97.3 |
| 4 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 53134.9 | 53134.9 | 0 | 100 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайлан гаргаагүй, үйл ажиллагааны болон орон нутгийн төсвөөс санхүүжих тогтмол зардлын дансаар гүйлгээ хийгдэж төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргадаг болсон байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 734876.4 мянган төгрөгөөс 75 хувиар буюу 8267.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бичиг хэргийн зардлыг 0.3, тээвэр шатахууны зардлыг 0.4, шуудан холбооны зардлыг 0.1, дотоод албан томилолтын зардлыг 2.7 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажиллажээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд 141 мэдээ мэдээлэхээс 114 мэдээг хугацаанд бүрэн мэдээлж, 27 буюу 01, 02 дугаар саруудын мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сэлэнгэ сумын ЭМТ нь 2022 оны томилолтын зардал олгохдоо нэг хоногийн 46.0, буудлын 80.0 мянган төгрөг буюу нийт 126.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

Иргэнтэй түлшний модны гэрээ байгуулсан боловч гэрээнд гоожингийн төлбөрийг байгууллагаас төлнө гэж тусгаагүй гоожингийн төлбөрт 680.0 мянган төгрөгийг төсвөөс шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

Сэлэнгэ сумын ЭМТ нь цалингийн зардлаас байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн Б/30 тоот “Урамшуулал олгох тухай” тушаал гаргасан нь ЭМС-ын болон аймгийн ЭМГ-ын даргын тушаал, шийдвэргүйгээр, ЭМС-ын 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 1а/3543 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг албан даалгавар гэж өөрчлөн, үндэслэлгүйгээр нийт 79200.0 мянган төгрөгийн тэтгэмж урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 6 дугаар зүйлийн 4 дэх заалтын 8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 1, 2, 9, 11, 12 саруудын шатахуун зарцуулалтыг тулгахад даргын цохолт илүү, жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй, хаашаа явсан нь тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэлтгүй 1365.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

Сэлэнгэ сумын ЭМТ нь Эрүүл мэндийн сайдын болон аймгийн ЭМГ-ын даргын тушаал шийдвэргүй, 2021 оны 11, 12 саруудад ковидын голомтод ажиллаагүй, шинээр 2022 оны 01 сард ажилд орсон 2 ажилтанд, мөн байгууллагын дарга тушаалын хавсралтад өөрийн нэрийг оруулан баталсан, мөн 2021 онд ЭМС-ын тушаалыг үндэслэж тэтгэмж урамшуулал, ковидын илүү цагийн нэмэгдэл зэргийг авсан бөгөөд давхардуулан 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Б/10 тоот “Урамшуулал олгох тухай” тушаалын 1 ба 2 дугаар хавсралтаар нийт ажилчдад 27500.0 мянган төгрөгийн тэтгэмж урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх заалтын 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 6 дугаар зүйлийн 4 дэх заалтын 8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын

бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

Бараа материалын тодруулга тайлангийн эм эмнэлгийн хэрэгслийн 86268.9 мянган төгрөгийн эхний үлдэгдлийг нярвын эмийн тайлангийн үлдэгдэлтэй тулгахад 35889.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 65000.0, 23000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг цалингийн зардлаас шилжүүлэхээр танилцуулахад сумын Санхүү албаны дарга болон төсвийн мэргэжилтэн нар холбогдох анхан шатны баримтын бүрдлийг хянаагүй, эрх нээж гүйлгээнүүдийг хийж ажлын хариуцлагагүй ажилласан нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх заалтын 7-д “төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;”, 37 дугаар зүйлийн 1 дэх заалтын 8-д “өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 65000.0, 23000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг цалингийн зардлаас шилжүүлж, ажилтан тус бүрд 3000.0 мянган төгрөгөөс 6000.0 мянган төгрөгийн хооронд тэтгэмж олгохдоо НДШ, ХХОАТ-ыг суутган тооцоогүй, ажилчдаар ХХОАТ болох 10 хувь буюу 8800.0 мянган төгрөгийг хүн тус бүрээр төлүүлж баримтыг хавсаргасан, төсвийн хөрөнгийг хяналтгүй зарцуулж байгаа тус сумын ЭМТ-ын дарга, нягтлан бодогч нар ажлын хариуцлагагүй ажилласан нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх заалтын 7-д “төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;”, 37 дугаар зүйлийн 1 дэх заалтын 8-д “өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Гэрэл цахилгааны зардлын гүйцэтгэлийг е баримтаар тулгахад 510.9 мянган төгрөгийн шивэлт дутуу шивэгдсэн байхад тооцоо нийлсэн актыг 581.75 төгрөгөөр баталгаажуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5-д “дансны

өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Тус байгууллага нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд 141 мэдээ мэдээлэхээс 114 мэдээг бүрэн мэдээлж 27 буюу 01, 02 дугаар саруудад мэдээлэх төсөв, гүйцэтгэлийн, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын, бусад мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;”, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор;” 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 9-д “хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар халаалтын зардлын 1292.9 мянган төгрөгийн авлагыг дутуу, мөнгөн гүйлгээний тайланд 25943.2 мянган төгрөгийн зардлын данс буруу илэрхийлсэн алдаа илэрснийг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-д “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулж ажилласан.

Шийдвэрлэсэн нь:

Алдааг залруулав.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Сэлэнгэ сумын ЭМТ нь 2022 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 45 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------------|----------|----------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 7 | 84535.1 | 7 | 84535.1 | 100 |
| Зөвлөмж | 1 | 1270.0 | 1 | 1270.0 | 100 |
| Нийт дүн | 8 | 85805.1 | 8 | 85805.1 | 100 |

Хэрэгжээгүй зөвлөмж байхгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зардлын зүйл ангиар зарцуулж ажиллах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 172.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 27.2 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан.

Үүнд: Авлагын тайланд авлагыг 1.3 сая төгрөгөөр дутуу, мөнгөн гүйлгээний тайланд 25.9 сая төгрөгийн зардлын данс буруу илэрхийлсэн.

Аудитаар нийт 145.3 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд 5 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Томилолтын зардал олгохдоо 126.0 мянган төгрөгийг илүү тооцсон, гоожингийн төлбөрийн 680.0 мянган төгрөгийг байгууллагаас шилжүүлсэн, ЭМС-ын болон аймгийн ЭМГ-ын даргын тушаал, шийдвэргүйгээр, ЭМС-ын 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 1а/3543 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг албан даалгавар гэж өөрчлөн, үндэслэлгүйгээр нийт 79200.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон, даргын цохолт илүү, жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй, хаашаа явсан нь тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу 1365.0 мянган төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан, ЭМГ-ын даргын тушаал шийдвэргүй, 2021 оны 11, 12 саруудад ковидын голомтод ажиллаагүй, шинээр 2022 оны 01 сард ажилд орсон 2 ажилтанд, мөн байгууллагын дарга тушаалын хавсралтад өөрийн нэрийг оруулан баталсан, мөн 2021 онд ЭМС-ын тушаалыг үндэслэж тэтгэмж урамшуулал, ковидын илүү цагийн нэмэгдэл зэргийг авсан бөгөөд давхардуулан 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Б/10 тоот “Урамшуулал олгох тухай” тушаалын 1 ба 2 дугаар хавсралтаар нийт ажилчдад 27500.0 мянган төгрөгийн тэтгэмж урамшуулал олгосон зэрэг зөрчлүүдэд 5 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Бараа материалын тодруулга тайлангийн эм эмнэлгийн хэрэгслийн 86268.9 мянган төгрөгийн, эхний үлдэгдлийг нярвын эмийн тайлангийн үлдэгдэлтэй тулгахад 35889.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 65000.0, 23000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг цалингийн зардлаас шилжүүлэхээр танилцуулахад сумын Санхүү албаны дарга болон төсвийн мэргэжилтэн нар холбогдох анхан шатны баримтын бүрдлийг хянаж ажиллаагүй, эрх нээж гүйлгээнүүдийг хийсэн, Сэлэнгэ сумын ЭМТ-ийн дарга, нягтлан бодогч нар нь ажлын хариуцлагагүй ажилласан зэрэг зөрчилд зөрчил арилгах 1, хариуцлага тооцох 2 албан шаардлагыг тус тус өгөхөөр шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.
Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Гэрэл цахилгааны зардлын гүйцэтгэлийн дүнг ө баримт болон тооцоо нийлсэн актын дүнтэй тулгахад 510.9 мянган төгрөгөөр шивэлт дутуу буюу зөрүүтэй баталгаажуулсан байна.

Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сэлэнгэ сумын ЭМТ нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд 141 мэдээ мэдээлэхээс 114 мэдээг бүрэн мэдээлж 27 буюу 01, 02 дугаар саруудад мэдээлэх төсөв, гүйцэтгэлийн, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын, бусад мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж хуулийн хугацаанд мэдээллийг бүрэн мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---------------------------------|------------|---------|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|---------|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Авлагыг дутуу | 1 | 1292.9 | | | | | 1 | 1292.9 | | | | |
| Зардлын данс буруу илэрхийлсэн. | 1 | 25943.2 | | | | | 1 | 25943.2 | | | | |
| Дүн | 2 | 27236.1 | | | | | 2 | 27236.1 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | | | | |
|--------------------|-------------|---------------|-----------------|---------|--------------------------------------|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |
| | | | | | | |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|--|-----|----------|-----|----------|-----|---------|-----|-------|-----|---------------------|-----|-----|
| Томилолтын зардалд илүү олгосон. | 1 | 126.0 | 1 | 126.0 | | | | | | | | |
| Түлшний модны эрхийн бичгийн төлбөрийг байгууллагаас шилжүүлсэн. | 1 | 680.0 | 1 | 680.0 | | | | | | | | |
| Тэтгэмж давхардуулан олгосон. | 1 | 27500.0 | 1 | 27500.0 | | | | | | | | |
| Тушаал шийдвэргүйг ээр цалингийн зардлаас урамшуулал олгосон. | 1 | 79200.0 | 1 | 79200.0 | | | | | | | | |
| Анхан шатны баримтын бүрдэлт дутуу, хаашаа явсан тодорхойгүй шатахуун зарцуулсан. | 1 | 1365.0 | 1 | 1365.0 | | | | | | | | |
| Ажлын хариуцлагагүй ажилласан. | 2 | 0 | | | | | | | 2 | 0 | | |
| БМ-ын тодруулга тайлангийн үлдэгдэл няравын тайлангийн үлдэгдэлтэй зөрүүтэй тайлагнасан. | 1 | 35889.9 | | | 1 | 35889.9 | | | | | | |
| Е баримтаар шивэгдсэн дүн, тооцоо нийлцсэн актын дүн зөрүүтэй. | 1 | 511.0 | | | | | 1 | 511.0 | | | | |
| Дүн | 9 | 145271.9 | 5 | 108871.0 | 1 | 35889.9 | 1 | 511.0 | 2 | 0 | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | |
|--------------------|-------------|---------------|-----------------|---------|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж |
| | | | | |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|--|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хугацаа хоцроож мэдээлсэн. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |